

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.13.1 дэх заалт, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.“Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас сул зогссон хугацааг тогтоох журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан журмыг хэрэгжүүлэх, ажил олгогчдод сурталчлан таниулахыг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт, мэргэжил, арга зүйгээр ханган ажиллахыг Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газар (Ц.Ганцэцэг)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (С.Лхагвадорж)-т, нийгмийн даатгалын мэдээллийн SICOS системд ажил олгогчийн үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас сул зогссон хугацаанд шимтгэлийн чөлөөлөлт үзүүлэх нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг Мэдээллийн технологийн төв (Г.Хүрэлбаатар)-д тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудит, мониторингийн газар (Б.Ганхуяг)-т даалгасугай.

ДАРГА

Б.БАТЖАРГАЛ

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГЫН УЛМААС СУЛ ЗОГССОН ХУГАЦААГ ТОГТООХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн дагуу үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас ажил олгогчид учирсан хохирлыг арилгах, хэвийн үйл ажиллагааг сэргээх зорилгоор сул зогссон хугацааг тогтооход энэхүү журмыг баримтална.

1.2.Энэ журмаар Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа, нийгмийн даатгалын байгууллагад бүртгэлтэй өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд (цаашид "ажил олгогч" гэх)-д гарсан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас сул зогссон хугацааг тогтооход холбогдсон харилцааг зохицуулна.

1.3.Ажил олгогчид гарсан үйлдвэрлэлийн осол, хурц хорлогын улмаас сул зогссон хугацааг тогтооход Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоолоор баталсан "Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм", Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 06 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан "Ажил олгогчид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, хяналт тавих журам" (цаашид "Ажил олгогчид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, хяналт тавих журам" гэх), холбогдох бусад хууль тогтоомж болон энэхүү журмыг мөрдөнө.

Хоёр.Хамрах хүрээ

2.1.Энэхүү журам нь ажил олгогч, даатгуулагч, Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газарт хамаарна.

Гурав.Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас сул
зогссон хугацааг тогтоох

3.1.Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас үйлдвэрлэлийн орчин, ажлын байранд техник технологийн хэвийн үйл ажиллагаа алдагдаж, тоног төхөөрөмж эвдэрсэн, барилга байгууламж нурсан, гал түймэр гарсан, цацраг болон биологийн идэвхт бодис, химийн хорт бодис алдагдсаны улмаас үүссэн нөхцөл байдлын хор уршгийг арилгах, хэвийн үйл ажиллагааг сэргээх зорилгоор тухайн ажлын байранд үйл ажиллагаа тасалдсан хугацааг үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас сул зогссон хугацаа (цаашид “ажил олгогчийн сул зогссон хугацаа” гэх) гэнэ.

3.2.Ажил олгогч нь энэ журмын 3.1-д заасан нөхцөл, байдал үүссэн тохиолдолд “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тухай яаралтай мэдэгдэх хуудас”, “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэсэн акт”, хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчийн акт, хууль, хяналтын байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоосон акт, актын үйлчлэлийг дуусгавар болгож, үйл ажиллагааг сэргээсэн акт болон сул зогссон ажлын байр, уг ажлын байранд ажилладаг ажилтнуудын бүртгэл, мэдээлэл зэргийг бүрдүүлнэ.

3.3.Ажил олгогч нь сул зогссон хугацааг тогтоолгох саналыг албан бичгээр гаргаж, энэ журмын 3.2-т заасан баримт бичгийн хамт харьяа аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газарт хүргүүлнэ.

3.4.Энэ журмын 3.3-т заасан аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газар нь ажил олгогчийн албан бичгээр ирүүлсэн санал холбогдох баримт бичгийг хүлээн авч, хянан Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (цаашид “Нийгмийн даатгалын ерөнхий газар” гэх)-д ирүүлнэ.

3.5.Нийгмийн даатгалын ерөнхий газар нь энэ журмын 3.2, 3.3-т заасан баримт бичгийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын мэдээллийн сантай тулган шалгаж, “Ажил олгогчид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, хяналт тавих журам”-ын 2.2-т заасан шаардлагыг хангасан ажил олгогчийн баримт бичгийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (цаашид “Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар” гэх)-д дүгнэлт гаргуулахаар хүргүүлнэ.

3.6.Нийгмийн даатгалын ерөнхий газар нь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дүгнэлтийг үндэслэн ажил олгогчийн сул зогссон хугацааг сараар тогтоон, баталгаажуулсан шийдвэрийг гаргаж, холбогдох аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газарт хүргүүлнэ.

Санамж: Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас тухайн сард 15 ба түүнээс дээш хоног сул зогссон тохиолдолд ажил олгогчийн сул зогссон хугацааг “1 сар”-аар тогтооно. Жишээ нь: “А” компанийн 1 дүгээр цех үйлдвэрлэлийн ослын улмаас 08 дугаар сарын 17-ны өдрөөс 12 дугаар сарын 05-ны өдөр хүртэл сул зогссон гэсэн дүгнэлт гарсан бол энэ тохиолдолд 1 дүгээр цехийн сул зогссон хугацааг “3 сар”-аар тогтооно.

3.7.Ажил олгогчийн сул зогссон хугацаанд үзүүлэх үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн чөлөөлөлтийг “Ажил олгогчид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, хяналт тавих журам”-ын 3.3, 3.4 дэх хэсэг болон уг журмын холбогдох бусад зохицуулалтуудыг баримтлана.

Дөрөв.Ажил олгогчийн сул зогссон
хугацааг бүртгэх

4.1.Нийгмийн даатгалын ерөнхий газар нь ажил олгогчийн сул зогссон хугацааны мэдээллийг ажил олгогч тус бүрээр үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын мэдээллийн санд бүртгэнэ.

4.2.Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газар нь энэ журмын 3.6-д заасан шийдвэрийг ажил олгогчийн хувийн хэрэгт хавсаргаж, бүртгэнэ.

Тав.Хяналт, хариуцлага

5.1.Энэхүү журмын хэрэгжилтэд Нийгмийн даатгалын ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар хяналт тавина.

5.2.Ажил олгогчийн сул зогссон хугацааг тогтоох баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсний улмаас үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлээс үндэслэлгүй эсхүл илүү чөлөөлүүлсэн бол буруутай этгээдээр шимтгэлийг нөхөн төлүүлж холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---o0o---